

НОМ ЗҮЙН ШИНЖ

**«МОНГОЛЫН БОЛОВСРОЛ, ЯСТ МЭЛХИЙН ЧУЛУУН
ХӨШӨӨ, ХОРШОО ҮГ»**

**(Токио, 1981) хэмээх номын тухай
(шүүмж)**

Сүүлийн үед Японы монголч эрдэмтэд Монголын соёл боловсролыг хөндөн бичих болж, энэ талаар эрдэм шинжилгээний өгүүлэл, ном гарч эхэллээ. Ялангуяа Монголын хэл соёл, боловсролын талаар нэлээд бүтээл бичсэн Ш. Озава, Ш. Хаттори, М. Хашимото, Ю. Канзава зэрэг эрдэмтдийг нэрлэж болно. Эдгээр эрдэмтдийн дотроос Ю. Канзана нь Монголын боловсролын талаар голлон судалж 1978 онд «Монголын ардын боловсролын систем», 1981 онд «Монголын боловсрол, яст мэлхийн чулуун хөшөө, хоршоо үг» зэрэг ном хэвлүүлснээс 1979—1980 онд түүний бичсэн «Монгол хэлэн дахь хоршоо үгийн тухай» эрдэм шинжилгээний цуврал өгүүлэл нь «Ажиа кэнкюжё сирё» сэтгүүлд нийтлэгджээ.

Монгол хэл судлаач, эрдэмтэн Канзава нь Япон дахь Азийн их сургуулийн Дорнодахины судлалын ангийг 1944 онд төгссөний дараа Васэда их сургуулийн утга зохиолын тэнхим, Токиогийн гадаад хэлний дээд сургуулийн дэргэдэх хэл судлалын хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан, 1958 оноос Азийн их сургуульд багшилж байв.

Тэрээр 1974, 1975, 1977, 1978, 1981 онд Монголд айлчлах үедээ үзсэн харсан зүйл болон баримт материал дээр тулгуурлан нэлээд зүйл бичсэн бөгөөд хамгийн сүүлд 1981 онд ирэхдээ «Монголын боловсрол, яст мэлхийн чулуун хөшөө, хоршоо үг» гэдэг номоо бичжээ. Уг ном нийт 3 бүлгээс бүрдэж байна. «БНМАУ-ын боловсрол» гэсэн гарчигтай 1-р бүлэг дотроо 6 зүйлтэй бөгөөд 2-р бүлэг болох Яст мэлхийн чулуун хөшөөн тухай Японд тархсан домог яриа нь дотроо 3 зүйлээс бүрдэнэ. 3-р бүлэгт Монгол хэлэн дэх хоршоо үгийн тухай өгүүлжээ. «Монгол нь хоцрогдсон нүүдэлчин улсаас богино хугацаанд өндөр соёлтой орон болсон бөгөөд ялангуяа боловсролын систем гайхалтай хөгжжээ» (7-р тал) гэж БНМАУ-ыг тунхагласнаас хойш 60-аад жилийн дотор ардын боловсролын салбарт олсон ололт амжилтыг зөвөөр үнэлжээ.

Зохиогч Монголын боловсролын асуудлыг 1911 оноос эхлэн ерөнхийд нь судлахдаа 1911-1919 он хүртэл монголын автономит үед бараг бүх хүн бичиг үсэг мэддэггүй, сүм хийдээс өөр ямар ч сургууль соёл байсангүй гэж бичжээ. (8-р тал) Ийм нөхцөлд соёлын хувьсгалын зүй тогтол өвөрмөцөөр илэрч хэрэгжснийг энд онцлон тэмдэглэх хэрэгтэй юм.

Монголын соёлын хувьсгал нь 1921 оны ардын хувьсгалын шууд үр дагавар, зүй ёсны үргэлжлэл байв. Оюун санааны ядуу дорой байдлыг үндсээр нь халж нийгмийн соёлын дэвшлийг хангах үйл явц гэнэт нэг өдөр бүтээгүй бөгөөд манай ард түмний олон жилийн шургуу тэмцэл, хөдөлмөрийн үр дүнд хэрэгжсэн билээ. Намаас шинэ соёлын төлөө явуулсан тэмцлийн нэн чухал чиглэл нь ардын боловсролын шинэ системийг үүсгэн хөгжүүлэх ёстой байсан бөгөөд энэ асуудлыг амжилттай шийдвэрлэснийг зохиогч «ардын боловсролын нэгдсэн системийг бий болгосон» (8-р тал) хэмээн дүгнэн бичжээ. Зохиогч цааш нь «1921 оны хувьсгалын үрээр тогтсон ардын засаг нь хөдөлмөрчин олны эрх ашгийг бүрэн тусгасан сургууль ба сургуулийн системийг шинээр байгуулснаар» (мөн тал хөдөлмөрчин олон түмэнтэй мах цусны холбоотой хувьсгалын үйл хэрэгт үнэнч, ардын шинэ сэхээтэн төрснийг нэлээн бодитойгоор өгүүлжээ.

Канзава нь АИХ-аас гаргасан 1946 оны тогтоол болон 1949, 1952 оны 8-р сард боловсролын талаар дэвшүүлэн тавьсан зорилтыг иш татаж, намын программд боловсролын хэтийн төлөв хэрхэн тусгагдсаныг дурдсанаас гадна 1921-1960 оны хоорондох боловсролын явцыг тус бүрд нь товчхон авч үзээд гол гол асуудлыг хөндөж бичсэн байна.

1966 онд хуралдсан МАХН-ын XV их хурлаар намын шинэ программыг баталсан бөгөөд үүгээрээ ардын боловсролын системийг цаашид боловсронгуй болгох, сургалтын агуулга, чанарыг сайжруулах, сургалтыг амьдралтай холбох, сургуулийн насны бүх хүүхдийг найман жилийн боловсролтой болгох нөхцөл байгааг цохон тэмдэглэснийг дурдаад 30-аад оны үед бага ангийн хамгийн хэрэгтэй номыг үнэ төлбөргүй олгож байсныг тэмдэглэжээ.

«Ардын боловсролын хөгжлийн салбарт 1940—1974 оны хооронд их амжилт олсон» (20-р тал) гээд юуны өмнө энэ хугацаанд дунд сургууль, техникум, ТМС байгуулж, түүнчлэн насанд хүрэгчдийн боловсролд ихээхэн анхаарсныг хэлэх хэрэгтэй гэжээ.

Шинжлэх ухаан, техникийн дэвшлийн өнөө үед дунд сургуулийн сургалтын агуулгыг тогтоосонтой холбогдож 1980-1985 оны хичээлийн жилд сургууль төгсөх сурагчдын дунд их ажил хийсний үр дүнд сургалтын шинэ программаар суралцаж байна (76-р тал) гэж тэмдэглэжээ. Энэ талаар МАХН-ын XVIII Их хуралд тавьсан илтгэлээс иш татаж «Одоо БНМАУ-ын эдийн засаг, соёлынхоо өсөлтийн үзүүлэлтээр Ази төдийгүй бусад тивийн олон орноос түрүүлж байна. Үүнийг тухайлбал хүн амын 10 мян. Хүн тутамд ноогдож буй сурагч, окутан, их эмч болон бусад мэргэжилтний тоо гэрчилж байна» гэжээ.

Зохиогч манай орны ерөнхий боловсролын сургалтын асуудлыг нэлээд нарийн судалж, энэ салбарт олсон амжилтыг манай тоо баримтад тулгуурлан он оноор харьцуулан үзсэн байна.

1940—1960 онд хичээл нэг бүрийн сургалтын аргын тухай багагүй ном гарч, ялангуяа монгол хэл, тооны хичээлийн заах аргын тухай олон үр дүнтэй судалгаа хэвлэгдлээ. (70-р тал) хэмээн цохон дурдсан байна.

Зохиогч манай төрийн хүнлэг бодлогыг харуулсан ардын боловсролын талаархи нам засгийн шийдвэрт нь боловсролын хөгжлийн нэг үндэс болсон сургуулийн барилга байгууламж тусгалаа олж байдгаас гадна мэдрэлийн согогтой болон эрхтэн дутуу, сул биетэй хүүхдүүдийн сурдаг тусгай сургууль байдгийг онцлон дурдаж дүгнэсэн байна

Зохиогч манай төрийн хүнлэг бодлогыг харуулсан ардын боловсролын талаархи нам засгийн шийдвэрт нь боловсролын хөгжлийн нэг үндэс болсон сургуулийн барилга байгууламж тусгалаа олж байдгаас гадна мэдрэлийн согогтой болон эрхтэн дутуу, сул биетэй хүүхдүүдийн сурдаг тусгай сургууль байдгийг онцлон дурдаж дүгнэсэн байна.

2-р бүлэгтээ зохиогч Японд дэлгэрсэн яст мэлхийн чулуун хөшөөний тухай домог яриаг бичээд Монголын Өвөрхангай аймагт байдаг яст мэлхийн чулуун хөшөөний тухай бичиж зургийн хамт нийтэлжээ. Азийн орнуудад тархсан (Энэтхэг, Зүүн Өмнөд Ази, Хятад, Монгол Солонгос), домог яриаг товчхон бичиж харьцуулжээ. Үүнээс үзэхэд дээрх орнуудад «дэлхий ертөнц анх яст мэлхийн бие дээр бий болсон», «дэлхийд ус, яст мэлхий хоёр л байсан» гэдэг ойлголт байсны улмаас энэ тухай адил төстэй домог яриа үүсч, дээрх орнуудад тархаж, үүнтэй холбогдон гарсан яст мэлхийн чулуун хөшөө, зураг зэрэг нь өнөө хүртэл хадгалагдан үлджээ. «Энэ талаарх Төв Азийн ард түмнүүдийн бодолтой Төвдийн төсөөллийг харьцуулахад хоёулаа бүрэн нийцэж байгаа нь анхаарал татаж байна» (107-р тал) гэсэн бөгөөд үүнийг цаашид судлууштай зүйл болов уу гэжээ.

Номын сүүлчийн бүлэгт Монгол хэлэн дэх хоршоо үгийн тухай бичиж үүнийгээ тодорхой жишээн дээр үзүүлжээ. Сүүлийн үед эрдэмтэн Канзава Монголын хоршоо үгийн талаар нэлээд судалгаа хийжээ. Японы эрдэмтэн Ш. Абэмацугийн «Монгол хэл ба Япон хэл» номонд орчин үеийн монгол хэлэнд монголч эрдэмтэд хоршоо үг гэж нэрлэдэг олон үг байгааг зохиогч дурдаад Б. Ринчингийн судалгаанаас Абэмацугийн иш татсан хоршоо үгийн «Толгой холбосон, сүүл холбосон» зэрэг 9 төрлийн ангиллыг жагсаан бичжээ.

Хоршоо үгийн тоо маш их бөгөөд монгол хэлний дүрэмд чухал байр суурь эзэлдэг гэж хэлэх хэрэгтэйг цохон тэмдэглэжээ. «Хоршоо» үгийн талаар Абэмацу судалгааны эхлэлийг тавьсан. Гэвч одоо энэ талаар өөр ашиглахаар судалгааны ажил байхгүй» (118-р тал) гэжээ. Иймээс ч Канзава энэхүү асуудалд анхаарлаа хандуулж үүнд судалгааны ажлаа чиглүүлжээ.

Зохиогч цагаан толгойн үсгийн дарааллар 53 үг шилж аваад үг тус бүрийг өгүүлбэрт оруулан монгол, япон хэл дээр харьцуулан бичсэн байна. Дашрамд хэлэхэд зохиогч нэлээд оновчтой үг шилэн авч 9 төрлийн хоршоо үгээс «утгаар адил хоршоо» үгийг сонгон авчээ. Энэхүү хоршоо үгийн талаарх судалгаа нь сонирхолтойгоос гадна ялангуяа хэл судлаачдын анхаарлыг зүй ёсоор татахуйц судалгааны ач холбогдолтой болжээ.

Японы монголч эрдэмтэн Канзава нь Монголын ардын боловсролын тухай голчлон сургууль багш, сурагчдын тоо баримтад тулгуурлан социалист бусад оронтой харьцуулах маягаар бичсэн бөгөөд ингэхдээ монголын боловсролын салбарт олсон ололт амжилтыг ихэд үнэлэн үзжээ. Ялангуяа зохиогч тус орны соёл боловсролын хөгжил дэвшлийг бичихдээ Л. Шагдарсүрэн, Ш.Лувсандэндэв зэрэг соёл боловсролын салбарын хүмүүстэй уулзаж, ардын боловсролын системд холбогдох ном зохиолыг ашиглан, мөн энэ салбарын хөгжилтийн нэг хэсгийг хот, хөдөөгийн хэд хэдэн сургууль дээр очиж үзсэндээ тулгуурлан бичжээ. Ийнхүү манай улсын боловсролын салбарт гарсан өөрчлөлт, хөгжилтийг японы эрдэмтэн Ю. Канзава судалгааны нэлээд тодорхой тоо баримтад тулгуурлан бодитойгоор үзжээ хэмээн дүгнэж болох байна.

Н. Бадамханд